



МОНГОЛ ШИЛТГЭЭН ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“МОНГОЛ ШИЛТГЭЭН” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 14 цагт Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Самбуугийн гудамж, “Орон зай” төв 7 давхарт 704 тоотод болов.

Хуралд :

Ч.Амарбаатар 7 633 345 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

“Таван толгой транс” ХХК 3 532 125 ширхэг хувьцааны саналаар /төлөөлөл/

Ж.Энхтунгалаг 25 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

С.Уранчимэг 10 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Д.Отгон 5 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

“МЖХЭНэгдсэн Холбоо” 1 ширхэг хувьцааны саналаар /төлөөлөл/

Г.Ганчимэг 4 317 511 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Ж.Баатар 2 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Ч.Мөнхбаяр 1 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

Ж.Сарангэрэл 10 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

М.Отгонбаатар 1 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/

15 483 036 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 82,8 % хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд болох М.Отгонбаатар, Мөнхбилэг, Гүйцэтгэх захирал М.Ган-эрдэнэ нар өөрийн биеэр оролцов.

Хурлыг компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Амарбаатар удирдав.

Хурлаар:

0. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
1. Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах;
2. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
3. Компанийн үйл ажиллагааг 4 улиралд шилжүүлэх төслийг танилцуулж хэлэлцэж батлах
4. Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх
5. Бусад асуудлыг тус тус хэлэлцэв.

Хурлын дарга: Тооллогын комисс ирцээ гаргасан бол танилцуулья. Хурал хүчин төгөлдөр болох ирц хүрсэн бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга С.Энхтуяа ирцийг танилцуулан, Тооллогын комиссын анхны тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 82,8 % хувьтай байгаа тул Монголын Улсын компанийн тухай хуулийн 69.1 д заасаны дагуу хурлын ирцыг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэв.

Хурал 14.20 минутанд эхлэв.

СОНССОН НЬ 1:

Хурлын дарга Ч.Амарбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тооллогын комисс дүнгээ гаргаад хурал эхлүүлэх зөвшөөрөлийг олгож байна ингээд хурлын дэгээ танилцуулья.

Хурлын дэгийн дагуу 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг гүйцэтгэх захирал танилцуулна.

Гүйцэтгэх захирал М.Ган-Эрдэнэ: 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн талаар танилцуулав.

2019 онд Монгол Шилтгээн ХК нь нийт 20 гаруй үндсэн ажилтан албан хаагчид, 10 гаруй гэрээт болон түр ажиллагсадтайгаар зуны үйл ажиллагааг компаний орлогыг нэмэгдүүлж зардалыг хэмнэх зорилго, уриатайгаар явуулж дуусгалаа.

Зөвхөн зуны 3 сар ажилладагаас хамаарч мэргэжлийн хамт олон, баг бүрдүүлэхэд хүндрэлтэй байдаг тул гэрээт ажилчид болон шаардлагатай үед

хөлсний ажилчид авч ажиллуулснаар хий зардалыг багасган ажилчдын хүчийг бүрэн дайчилан ажиллав.

Зуны шоу наадмууд, эвент хүлээн авалтууд, байгууллагуудын амралт зугаалгуудыг амжилттай зохион байгуулж, буудлын хүчин чадлыг бүрэн ашиглах тал дээр анхааран урсгал засварыг тогтмол хийж, олон хүнийг зэрэг хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх тал дээр анхаарч ажиллалаа.

Рестораны хүчин чадал 200 хүнээс хэтэрдэггүйгээс шалтгаалан олон хүний хурим найрыг хүлээн авах боломжгүй байдагаас гадна хүмүүс зуны цагт гадаа талбайд хурим хийх сонирхол их байдгийг үндэслэн гаднаа 2000 гаруй м2 талбайд 30-аад сая төгрөгний хөрөнгө оруулалтаар бетон цутгалт хийж тайз засан анх удаа гадаа болон дотор 2 хуримыг зэрэг хүлээн авлаа. Уг талбайдээрээ сагсны шит байрлуулан бусад үед нь амрагчдын идэвхтэй амрах нөхцлийг бүрдүүлэн ажиллав.

Мөн Чингисийн өргөө, дэлгүүрийн барилга, наадмын талбайн дээвэр зэрэгт 10-аад сая төгрөгний хөрөнгө оруулалт хийн засаж сайжруулав.

Монгол Шилтгээн ХК-ий бүх байрууд жилээс жилд элэгдэлд орж дээврүүд нь муудан, гаднаасаа нурж дотроо хүйтэн, чийгтэй, мөөгөнцөртсөнөөс гадна бороо орсны дараа ус гоожин бараг өдөр бүр дээвэр янзлах, тааз, ханын цаас солих, шал будах г.м. урсгал засварын ажилд маш их үргүй зардал, хөрөнгө мөнгө, хүн хүч зарцуулах шаардлага үүсч байв.

“Монгол шилтгээн” ХК нь шүүхийн шийдвэрээр амралтын цогцолбор /1967 м. кв/ барилга, 36,000 /м. кв/ газрын хамт Голомт банкны барьцаанд, шийдвэр гүйцэтгэлийн түвшинд, компанийг дампууруулах шүүхийн шийдвэрийн дарамтанд байснаас шалтгаалан банкны дансууд битүүмжлэгдсэн, орсон мөнгийг шүүхийн шийдвэр татан авч байснаас гадна бусад төрийн байгууллагуудаар үйлчлүүлж өөрчлөлт хийлгэх г.м. хөдөлгөөнүүд хаалттай байсан нь компани хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байсан болно.

Энэ 2020 оны хувьд тахалын улмаас бүх шоу наадмууд цуцлагдсан, мөн олон хүнийг бөөгнөрүүлж болохгүй гэсэн шаардлагуудаас шалтгаалан орлого олох үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй болж байна.

Цаашид компани хэвийн ажиллахын тулд дээвэр болон байруудад бүрэн засвар хийж халаалт, усны системийг бий болгон ядаж 10 сарыг дуустал ажилладаг болгохын тулд нилээн их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа болно.

ТУЗ-ийн хараат бус гишүүн С.Мөнхбилэг: Санал гаргая. Үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлантай танилцлаа. Компанийн бизнес төлөвлөгөө болон ажиллах, ажлуулахгүй шийдвэрийг ТУЗ дээрээ хэлэлцээд шийдвэрлээд явах нь зүйтэй гэж үзэж байна тиймээс дараагийн асуудалаа хэлэлцээд явбал яасан юм бэ?

СОНССОН НЬ 2:

ТУЗ-ийн дарга Ч.Амарбаатар: 2023 онд ногдол ашиг хуваарилахгүй байх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг уншиж танилцуулав.

ТУЗ-ийн хараат бус гишүүн С.Мөнхбилэг: Ногдол ашиг хувиарлах шийдвэрээ батлах уу.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ариунсайн: ТУЗ шийдвэрийг гаргадаг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулдаг.

СОНССОН НЬ 3:

ТУЗ-ийн дарга Ч.Амарбаатар: Голомт банкны шүүхийн маргаан БЗД ийн шүүхэд дампууруулахаар өргөдөл өгсөнтэй холбогдуулаад компанийн томоохон хувьцаа эзэмшигч өр төлбөрийг нь барагдуулсан тухай асуудал байгаа.

Компанийн өрийг хувьцаагаар солих шийдвэр өнгөрсөн жилийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар өрийг хувьцаагаар солих шийдвэрийг гаргасан.

Уг шийдвэрийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, тогтоолууд гарж бид өр төлбөрөө барагдуулж улсын бүртгэл банкнууд дээр байсан блокнуудаа гарч компани үйл ажиллагаа цаашид хэвийн явах горимд шилжиж байна. Та бүгдэд тараагдсан хурлын материал дотор СЗХ тогтоол байгаа.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ариунсайн: Бид компанийн өрийг хувьцаанд хөрвүүлсэнтэй холбоотой хувьцаа эзэмшигч нартаа тэргүүн ээлжинд хувьцааг худалдан авах давуу эрхийг эдлүүлсэн мөн шаардах эрх гээд хувьцаа эзэмшигчдийн эрхийг хангаж ажилласан.

ТУЗ-ийн дарга Ч.Амарбаатар: Өнгөрсөн жилүүдэд бид нэлээн хүнрэлтэй ажиллаа. Ковид-19 мөн Голомт банк дампууралын хэрэг үүсгэж, банкны дансыг хааж, туулж болох бүх л саад бэрхшээлтэй нүүр туллаа.

Өнгөрсөн жилүүдийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу Голомт банкны өрийг хувьцаан хөрвүүлэх ажлыг амжилттай хийж гүйцэтгэж Санхүүгийн Зохицуулах хорооноос 2024 оны 02 дугаар сарын 23 өдрийн 48 тоот тогтоолоор 8 620 690 ширхэг хувьцааг нэмж гаргахыг зөвшөөрсөн. Энэ ажлыг хийж гүйцэтгэсэн ТУЗ болон гүйцэтгэх удирлагын багдаа хувьцаа эзэмшигчдийн зүгээс баярласан талархсанаа илэрхийлье.

Бид компани мөнгө байхгүй учраас 8 620 690 ширхэг хувьцааг нэмж гаргахыг ажлыг маш бага зардалаар амжилттай хийж дуусгасан.

Мөн “Компанийн тухай хууль”-ийн 25 дугаар зүйл, 62.1.3-р зүйл, 38 дугаар зүйлд заасны дагуу компанид хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг хэрэгжүүлэх компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь компаниас нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлж, Компаний тухай хуулийн 53.1, 53.1.2-р зүйлд заасны дагуу компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авах шаардах эрхийг эдлүүлж хувьцаа эзэмшигчдийнхээ эрхийг хамгаалж ажилласанаа дуулгахад таатай байна.

СОНССОН НЬ 4:

ТУЗ-ийн дарга Ч.Амарбаатар: Компанийн үйл ажиллагааг улиралын чанартай биш тасралтгүй жилийн 4 улиралын болгох хэрэгтэй байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн С.Мөнхбилэг: ТУЗ-д ярьмаар байна. Жил жилийн төлөвлөгөөг ТУЗ дээр ярилцаад явдаг батлаад

Шийдвэрээ амжилттай гаргалаа. Ээлжит хурал маань амжилттай болж дууслаа. Та бүхэндээ маш их баярлалаа.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2023 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн тогтоолыг танилцуулсаныг дурьдсугай.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

4. Хэлэлцэх асуудал дууссан тул хурал 15 цаг 40 минутанд өндөрлөв.

Г.М. [Signature]

УЛААНБААТАР Т. 3067308

М.АМАРБААТАР/

4.  

/ А.АРИУНСАЙН /